

## ЭМЧИЛГЭЭНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ВИЗ МЭДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

20.. оны ... дугаар  
сарын .....-ний өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас: ..... тоот тусгай зөвшөөрөлтэй “.....” компани (цаашид “Компани” гэх)-ийг төлөөлж, Итгэмжлэгдсэн төлөөлөгч .....,

нөгөө талаас: Монгол улсын иргэн ..... (РД: .....), (цаашид “Үйлчлүүлэгч” гэх) нар Монгол улсын “Иргэний хууль”-ийн холбогдох зүйл заалтыг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү “Эмчилгээний аялал жуулчлалын виз мэдүүлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээгээр Компани нь Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу .....-д эмчилгээний аялал жуулчлалын виз мэдүүлэх, эмнэлэг захиалга болон онгоцны тийз захиалах, аялалтай холбогдох үйлчилгээг үзүүлэх, Үйлчлүүлэгч нь эмчилгээний аялал жуулчлалын визийн үйлчилгээнд өөрийн зүгээс гаргаж өгөх мэдээллийг үнэн зөвөөр мэдүүлэх, гэрээнд заасан хугацаанд шимтгэл хураамжийг төлөх, Компаниас тавьсан шаардлагыг биелүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.

1.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

1.3. Компани нь .....-ын Хууль зүйн Яам, Эрүүл мэндийн Яамнаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эмчилгээний аялал жуулчлалын виз мэдүүлэх, түүнийг сунгуулахаар хандах эрхтэй боловч эрх бүхий байгууллагаас Үйлчлүүлэгчид виз олгох, сунгах шийдвэр гаргахад оролцох эрхгүй тул уг асуудлаар баталгаа гаргахгүй бөгөөд Үйлчлүүлэгч нь уг нөхцөл байдлыг бүрэн ойлгож, ухамсарлаж буйгаа үүгээр илэрхийлж байна.

1.4. ....

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Энэхүү гэрээг талууд 20..... оны ..... дугаар сарын .....-ний өдөр байгуулсан бөгөөд Үйлчлүүлэгчид .....-д нэвтрэх виз олгох хүртэл хугацаатайгаар байгуулав.

2.2. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох ба аялал эхэлсэн эсхүл аялал эхлүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд дуусгавар болно.

### Гурав. Төлбөр тооцоо, түүнийг төлөх, буцаан авах журам

3.1. Төлбөр тооцоо: Үйлчлүүлэгчээс Компанид төлөх виз мэдүүлэх үйлчилгээний нийт төлбөр нь ..... ам.доллар байна.

3.2. Төлбөр тооцоог шилжүүлэх: Үйлчлүүлэгч нь гэрээний 3.1-д заасан төлбөрийг гэрээ байгуулсан өдөр Компанид бэлнээр эсхүл Компанийн ..... банкин дахь ..... тоот төгрөг/валютын дансанд шилжүүлнэ.

3.3. ....



## **Дөрөв. Барьцаа**

4.1. Үйлчлүүлэгч нь өөрийн төлбөл зохих төлбөр тооцоог бүрэн барагдуулах баталгаа болгож, банкинд энэхүү гэрээний 4.2-т заасан барьцааг байршуулж, гэрээ байгуулна.

4.2. ....

### **Тав. Компаниас үзүүлэх үйлчилгээ**

5.1. Компани нь энэхүү гэрээний дагуу Үйлчлүүлэгчид эмчилгээний аялал жуулчлалын виз мэдүүлэхтэй холбогдуулан дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

5.1.1. Виз мэдүүлэхэд шаардагдах баримт бичгийн бүрдүүлбэрийг Үйлчлүүлэгчид танилцуулах;

5.1.2. Үйлчлүүлэгчийн хүлээлгэн өгсөн баримт бичгийг түүний өмнөөс эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх, хариу авах;

5.1.3. Үйлчлүүлэгч үргэлжлүүлэн эмчлүүлэх шаардлагатай нөхцөлд эмчилгээний аялал жуулчлалын визийг сунгуулах материалыг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч, хариуг авах.

5.2. Компани нь энэхүү гэрээний дагуу Үйлчлүүлэгчид эмчилгээний захиалга хийхтэй холбогдуулан дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

5.2.1. Үйлчлүүлэгчийн хүсэл сонирхолд нийцсэн эмнэлгийн байгууллагыг танилцуулах;

5.2.2. Үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эмнэлгийн байгууллагад захиалга өгөх, эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах хугацааг Үйлчлүүлэгчид мэдэгдэх;

5.2.3. ....

### **Зургаа. Компанийн эрх, үүрэг**

6.1. Компани нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

6.1.1. Үйлчлүүлэгчээс өвчний онош, шинжилгээний хариу болон бусад шаардлагатай баримт бичгийг тохиролцсон хугацаанд, үнэн зөвөөр гаргаж өгөх, тэдгээрийн үнэн зөвийг өөрөө хариуцахыг шаардах;

6.1.2. Үйлчлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас Компанид учруулсан бодит хохирлыг нэхэмжлэх;

6.1.3. ....

6.2. Компани нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

6.2.1. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу үйлчилгээг мэргэжлийн түвшинд, чанартай үзүүлэх;

6.2.2. ....

### **Долоо. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

7.1. Үйлчлүүлэгч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

7.1.1. Компаниас энэхүү гэрээний дагуу гүйцэтгэж буй үйлчилгээний явц, үр дүнгийн талаар мэдээлэл авах, үнэн зөв мэдээллээр хангахыг шаардах;

7.1.2. Эрх бүхий байгууллагаас Үйлчлүүлэгчид виз олгохыг зөвшөөрөөгүй тохиолдолд шимтгэл хураамжийг гэрээнд заасан хувь хэмжээгээр буцаан олгохыг шаардах;

7.1.3. Энэхүү гэрээг цуцлах тухай санал гаргах эрхтэй.

7.2. Үйлчлүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.2.1. Үйлчлүүлэгч нь .....-д оршин байх хугацаанд тус улсын хууль тогтоомж, эмнэлгийн дүрэм журам болон энэхүү гэрээний заалтыг чанд сахин биелүүлэх, ийнхүү биелүүлээгүйгээс үүдэн гарсан эрсдэл, хариуцлагыг өөрөө бүрэн хариуцах;

7.2.2. Виз хүсэхэд өөрийн зүгээс шаардлагатай баримт бичгийг үнэн зөвөөр, тогтоосон хугацаанд бүрэн гаргаж өгөх;

7.2.3. ....

*Үргэлжлэл бий .... /7х/*